

2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн
05 дугаар тогтоолын хавсралт



АВТОЗАМ ЗАСВАР АРЧЛАЛТЫН ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛД НЭР ДЭВШИГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Увс А33А” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд иргэн/цаашид “нэр дэвшигч гэх” /-ийг нээлттэй сонгон шалгаруулах ажиллагаа /цаашид “сонгон шалгаруулалт гэх”/ энэ журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3. Сонгон шалгаруулалт нь сонгон шалгаруулалтыг зарлах, нэр дэвшигчийн бичиг баримтыг хүлээн авах, дүгнэх үйл ажиллагаа болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтээс бүрдэнэ.

1.4. Төлөөлөн удирдах зөвлөл сонгон шалгаруулалт явуулах хугацааг товлону.

1.5. Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигчдэд тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэн тогтоож энэхүү түр журмыг хэрэгжүүлж ажиллана.

1.5. Нэр дэвшигчийн баримт бичгийн агуулга, нууцлалыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон Нэр дэвшүүлэх хороо хариуцна.

1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга сонгон шалгаруулалтад техник, зохион байгуулалтын тусалцаа үзүүлнэ.

1.7. Сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод байх, шударга ёсыг эрхэмлэх, хууль дээдлэх зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

Хоёр. Сонгон шалгаруулалтын үнэлгээ

2.1. Нэр дэвшүүлэх хороо сонгон шалгаруулалтын хүрээнд бичиг баримтын шалгаруулалт /цаашид “ерөнхий шалгалт” гэх / болон тусгай шалгалтыг зохион байгуулж, сонгон шалгаруулалтыг 100 оноогоор үнэлнэ. Нэр дэвшигч нь энэхүү журамд заасан шаардлагыг хангасан эсэх байдлыг үнэлж дүгнэлт гаргана. Нэр дэвшигчийн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль¹, Компанийн тухай хууль², Авлигын эсрэг хууль³, Хөдөлмөрийн тухай хууль⁴, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль⁵, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай⁶ болон Төрийн хэмнэлтийн тухай⁷ хуулийн эрх зүйн мэдлэг, монгол хэл бичиг, хэрэглээний программ ашиглах баримт бичиг боловсруулах зэрэг чадвар болон ярилцлагын үнэлгээгээр тусгай шалгалтыг дүгнэнэ.

2.2. Сонгон шалгаруулалтад нэр дэвшигчийн ерөнхий шалгалтын үнэлгээ нь үнэлгээнд авбал зохих 100 онооны 30 оноо авсан тохиолдолд тусгай шалгалт өгөх эрхтэй болно.

2.2.1. Ерөнхий шалгалтын үнэлгээг Нэр дэвшүүлэх хорооны гишүүн тус бүр



үнэлгээний хуудсаар өгч нийт гишүүдийн дунжаар сонгон шалгаруулалтын оноог гаргана.

2.3 Нэр дэвшүүлэх хороо нь ерөнхий болон тусгай шалгалтын нийлбэр оноогоор хамгийн өндөр үнэлгээ авсан нэр дэвшигчийн баримт бичгийг дүгнэлтийн хамт Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлнэ.

2.4. Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын дүн, дүгнэлтийг 3 ажлын өдрийн дотор гаргаж, зөвхөн ерөнхий шалгалтад тэнцсэн нэр дэвшигчдэд утсаар мэдэгдэнэ.

2.5.Төлөөлөн удирдах зөвлөл нь Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж зохих шийдвэрийг гаргуулна.

2.6. Нэр дэвшүүлэх хорооноос тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангасан Монгол Улсын иргэн уг сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй.

2.7.Төрийн өмчит компанид гүйцэтгэх удирдлагын эрх хэрэгжүүлдэг нь давуу эрх эдлэх нөхцөл болохгүй.

Гурав. Ерөнхий шалгалтын үнэлгээ

3.1. Нэр дэвшигчийн ерөнхий шалгалтыг дараах байдлаар үнэлнэ:

3.1.1. боловсрол 10 хүртэл оноо;

3.1.2. мэргэжил 10 хүртэл оноо;

3.1.3. тухайн салбарын ажлын туршлага 5 хүртэл оноо;

3.1.3.1. тухайн салбарт ажилласан байдлыг нотлох нийгмийн даатгалын лавлагаа.

3.1.4. Бичиг баримтын бүрдэл 5 хүртэл оноо.

3.1.4.1. иргэний үнэмлэхийн лавлагаа

3.1.4.2. Төрийн албан хаагчийн анкет (2022 он, маягт № 1);

3.1.4.3. боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн хуулбар, QR кодтой дээд боловсрол эзэмшсэн лавлагааны хамт;

3.1.4.4. гадаадад их, дээд сургууль төгссөн бол дээд боловсролын дипломын хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн баталгаат орчуулгын хамт;

3.1.4.5. ажилласан жилийг тооцох нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн QR кодтой лавлагаа;

3.1.4.6. нэр дэвшигч болон түүний хамаарал бүхий этгээдийн хугацаа хэтэрсэн зээлийн лавлагаа /сонгон шалгаруулалтын баримт бичиг ирүүлэх өдрөөр/

3.1.4.7.Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт

3.1.4.8.Иргэний, эрүүгийн хэргийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт

3.1.4.9.Урьд нь ажиллаж байсан 2-оос доошгүй байгууллагын эрх бүхий албан тушаалтны баталгаажуулсан ажил байдлын тодорхойлолт;

3.1.4.10.Сонгон шалгаруулалт зарласан албан тушаалд хамаарах байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөр.

Дөрөв. Тусгай шалгалтын үнэлгээ

4.1. Сонгон шалгаруулалтад оролцогч нэр дэвшигчийн мэдлэгийг тусгай шалгалтаар дараах байдлаар тус тус үнэлнэ:

4.1.1. эрх зүйн мэдлэг /сорил/ 35 хүртэл оноо;

4.1.2. монгол хэлний болон программ хангамжийн мэдлэг 15 хүртэл оноо;

4.1.3. баримт бичиг боловсруулах чадвар 5 хүртэл оноо;

4.1.4. Ярилцлага 15 хүртэл оноогоор үнэлсэн байна.

Тав. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

5.1. Сонгон шалгаруулалтыг өдөр тутмын хэвлэлд 21 -ээс доошгүй хоногийн өмнө зарлана.

5.2. Сонгон шалгаруулалтын зард нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тусгай шалгалтын тухай, баримт бичгийг хүлээж авах газар, огноо, цаг хугацаа, албан тушаалтны нэр, хаяг, утас болон холбогдох бусад мэдээллийг тусгана.

5.3. нэр дэвшигч бүртгэлийн хураамж 50.000 төгрөгийг тухайн төрийн өмчит хувьцаат компанийн тоот дансанд тушаасан байна. Сонгон шалгаруулалтад тэнцээгүй нэр дэвшигчийн бүртгэлийн хураамжийг буцааж олгохгүй.

5.4. нэр дэвшигч нь сонгон шалгаруулалтын ерөнхий шалгалтын буюу баримт бичгийг цагаан өнгийн А4 хэмжээтэй дугтуйнд хийж битүүмжлэн овог нэр, нэр дэвшиж буй албан тушаал, утас хаягийг зүүн дээд буланд тодорхой бичсэн байна.

5.5. бүртгэлтэй холбоотой гомдлыг нэр дэвшигч сонгон шалгаруулалт эхлэхээс 3 хоногийн өмнө Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны даргад бичгээр гаргана.

5.5.1 Нэр дэвшүүлэх хорооны дарга гомдлыг үндэслэлтэй эсэхийг нягтлан шалгаж хариуг бичгээр 2 хоногийн өмнө өгнө.

5.2. Нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичиг нь чанар байдлын хувьд үнэлэх боломжгүй, хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлсэн нь илэрсэн тохиолдолд баримт бичгийг үнэлэхгүй, нэр дэвшигчийг бүртгэлээс хасаж бүртгэлийг хүчингүйд тооцно.

Зургаа. Нэр дэвшигчдэд хориглох зүйл

6.1. Нэр дэвшигчдэд дараах зүйлсийг хориглоно:

6.1.1. сонгон шалгаруулалтын хэвийн үйл ажиллагаанд саад учруулах;

6.1.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүдэд нөлөөлөх;

6.1.2. шалгалт эхлэх хугацаанаас хожимдох;

6.1.3.шалгалтын явцад бусдад саад учруулах, ярилцах, бусдын гүйцэтгэлийг харах, ашиглах;

6.1.4. өөр хүнийг шалгалтад оруулах;

6.1.5. шалгалтын материалд тэмдэг, тэмдэглэгээ хийх

6.1.6.сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалт зарласнаас эхлэн сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар эрх бүхий этгээдтэй биечлэн уулзах, утсаар ярих, цахимаар харилцах;

6.1.7. сонгон шалгаруулалтын үнэлгээнд урьдчилан нөлөөлөх гэсэн аливаа хууль бус оролдлого хийх.

Долоо.Бусад

7.1. Энэхүү журмыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудас болон тухайн төрийн өмчит компани цахим хуудсанд байршуулна.

7.2. Энэхүү журам нь сонгон шалгаруулалтад нэр дэвшигч Гүйцэтгэх захиралд томилогдсоноор үйлчлэх хугацаа дуусгавар болно.

.....ОоО.....